# ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэ -лийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***“Зоонозын өвчнийг тандах, хянах, эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээг эмч мэрэгжилтнүүдийн туршлага, чадавхид үндэслэн, судалгаа, шинжилгээ, нотолгоонд тулгуурлан, оновчтой бүтэц, эрх зүйн орчин бүрдүүлэн халдварын эрсдэлийг бууруулах замаар хүн амыг өвчлөл, эндэгдлээс урьдчилан сэргийлэх”*** | | | | | | | |
| **Зорилт 1. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед авах хариу арга хэмжээний бэлэн байдал, чадавхийг сайжруулах** | | | | | | | |
| 1.1 | **МУХТЖҮЧ 2.2.1; МУЗГҮАХ 1.1.3.4** Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед хэрэглэх нөөцийн агуулах ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | - | Нөхөн хангалтын хувь | Агуулахын барилгын 90 хувийн явцтай. | Үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Эрүүл мэндийн яам, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захиалгаар Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төслийн хүрээнд Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хороонд байрлах Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн эзэмшлийн газарт барьсан “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн эрүүл мэндийн салбарын нөөц”-ийн барилгыг ашиглалтад бүрэн оруулж, ЭМЯ-ны удирдлагын зөвлөлийн хурлаар ЗӨСҮТ-ийн эзэмшилд байлгахаар шийдвэрлүүлж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/171 дүгээр тушаалаар ЗӨСҮТ-ийн дэргэдэх эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахын дүрмийг баталгаажуулан мөрдөн ажиллаж байна. 2022 онд НЭМ-ийн онцгой байдлын үед ашиглах 16 нэр төрлийн, 112 696 ш эм тариа, 200 багц 106700 ш тоног төхөөрөмж, 1 869362 ш хамгаалах хувцас хэрэгслийг нөөцлөөд байна | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2 | **“Алсын хараа”- 2050; МУХТЖҮЧ 2.2.1; 2.2.10; МУЗГҮАХ 1.1.3**<br>Тохиолдлын удирдлагын тогтолцооны төлөвлөгөөг шинэчилж хэрэгжүүлнэ. | - | Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | ЗМА-ТУТ-ны төлөвлөгөөнд 6 удаа тодотгол хийсэн. | Төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн байна. | Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбоотой Зоонозын мэргэжлийн анги-Тохиолдлын удирдлагын тогтолцооны зохицуулагчийн тушаалаар ТУТ-ны төлөвлөгөөг 1 удаа тодотгож, ЗМА-ТУТ-ны шуурхай хурлыг шаардлагатай тохиолдолд тухай бүрт хуралдуулж үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09 дүгээр албан даалгаврын хүрээнд ТУТ-ны төлөвлөгөөг төвийн захирлын тушаалаар шинэчлэн батлуулж, Коронавируст халдварын Омикрон хувилбарын болзошгүй тархалттай холбоотой 5 зорилтын хүрээнд 19 үйл ажилгааг төлөвлөн, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. | 100% |
| 1.3 | **МУЗГҮАХ 1.1.3**<br>Коронавируст халдвар /ковид-19/-ын үед суурин болон явуулын вирус судлалын лабораторийн бэлэн байдлыг хангаж, лабораторийн шинжилгээ хийнэ. | - | Шинжилсэн сорьцийн тоо | Короновирүст халдварын үүсгэгч илрүүлэх шинжилгээг нийт 364577 сорьцод хийсэн. | Коронавируст халдвар /ковид-19/-ын үед суурин болон явуулын вирус судлалын лабораторийн бэлэн байдлыг хангаж, лабораторийн шинжилгээ хийнэ. | Тус төвийн вирүс судлалын суурин болон явуулын авто лабораторит нийт 24411 сорьц шинжилснээс 23029 сорьцыг бодит цагийн ПГУ-аар, 1382 сорьцыг хурдавчилсан тестийн аргаар шинжиллээ.<br>Шинжилгээгээр 3340 сорьцонд SARS-CoV2 эерэг тодорхойлогдсон байна. Оношлуурын 3 сарын нөөцийг тогтмол хангаж ажиллаж байна. Хоёр мэргэжилтнийг Саратовиын “Микроб” институтэд молекул биологийн чиглэлээр 2 сарын сургалтад хамруулсан. | 100% |
| 1.4 | **МУЗГҮАХ 1.1.3**<br>Коронавируст халдвар /ковид-19/-ын үед биоаюулгүй ажиллагаа, халдваргүйжүүлэлтийн талаар эрүүл мэндийн болон бусад байгууллагуудад сургалт зохион байгуулна. | - | Сургалтын тоо<br>Хамрагдсан байгууллагын тоо<br>Эрүүл мэндийн ажилтны тоо | 4000 орчим ажилчдад цахим, танхим, дадлага сургуулилт хэлбэрээр сургалтуудыг үе шаттай зохион | Төлөвлөгөөт сургалтыг зохион байгуулсан байна. | Булган, Орхон, Дархан-Уул, Төв аймгийн ЭМГ, БОЭТ, ӨЭТМ, МЭГ, МХГ, Онцгой байдал, Цагдаагийн байгууллагын эмч, мэргэжилтэн 158 хүнд 4 удаа "Халдвараас сэргийлэх хяналтыг чадавхжуулах" сэдэвт сургалтыг удирдамжийн дагуу | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулж, сургаж, дадлагажуулсан. | | “Урьдчилан сэргийлэх болон голомтын халдваргүйжүүлэлт хийх, анхаарах асуудлууд”, “Нэг удаагийн хамгаалах хувцас хэрэглэлийг өмсөх тайлах” дадлага сургалтуудыг зохион байгуулав. Хятадын элчин сайдын газар, Туушин зочид буудлын 53 үйлчилгээний ажилчдад Халдваргүйжүүлэлт хийхэд анхаарах зүйл, халдваргүйтгэлийн бодисын талаар сургалт зохион байгуулсан. Цагдаагийн ерөнхий газар Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас ирсэн 10.2/2068 тоот албан тоотын дагуу салбар төвүүд болон тухайн байгууллагын үйлчлэгч нарт Халдваргүйжүүлэлт, халдваргүйжүүлэх бодисыг хэрэглэх, найруулах аргын талаар цахим сургалтыг зохион байгууллаа. Коронавируст халдвар (Ковид-19)-аас урьдчилан сэргийлэх БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ тархвар судлагч эмч нарт Нийт 216 хүнд сургалт зохион байгуулсан. | |
| 1.5 | Зоонозын шалтгаант үйл явдал болон тохиолдол бүртгэгдсэн үед эрсдлийн үнэлгээг тухай бүр хийнэ. | - | Эрсдлийн үнэлгээний дүн | Тарваган тахал, Боом, Шүлхий зэрэг өвчний үед нийт 6 удаа эрсдэлийн үнэлгээг хийсэн. | Эрсдлийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг холбогдох газарт хүргүүлж голомтыг цомхотгох арга хэмжээг авсан байна. | 2022 онд нийт тарваган тахал өвчний сэжигтэй 6 тохиолдол бүртгэгдсэнээс 3 удаа, боом өвчний сэжигтэй 4 тохиодол бүртгэгдсэнээс 2 удаа нийт 5 удаа эрсдэлийн үнэлгээ хийж, эргэн мэдээлэл, зөвлөмжөөр ханган ажилласан. 2022 онд Монгол Улсын Шадар сайдын 2017 оны А/08 тоот тушаалаар батлагдсан Эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлгээг салбар хоорондын байгууллагууд хамтран 29 удаа хийж гүйцэтгэв. Эрсдэлийн үнэлгээний аргачлалын дагуу “Монгол улсад коронавируст халдвар (КОВИД-19)-ын омикрон хувилбараар үүсгэгдсэн дэгдэлт бүртгэгдсэнтэй холбоотой “SARS-CoV-2 вирусийн омикрон хувилбараар үүсгэгдсэн халдварын улмаас үүсэх эрсдэл”- ийн үнэлгээг ХӨСҮТ, тэргүүлж УОКШШ, ЭМЯ, ДЭМБ, ОБЕГ, МХЕГ, ГЕГ, НЭМҮТ, ТЕГ, ЗӨСҮТ зэрэг байгууллагууд хамтарч оролцов. Эрсдэлийн үнэлгээнд магадлалын түвшин тогтоох 19 асуултнаас 12 (63.1%) тийм, Үр дагаврын түвшин тогтоох 18 асуултнаас 8 (44.4%) тийм гэсэн хариулттай эрсдэлийн үнэлгээний дүн ДУНД ЭРСДЭЛТЭЙ үнэлэгдлээ. | |
| 1.6 | Зоонозын шалтгаант үйл явдал, тохиолдол, дэгдэлт, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед нотолгоонд суурилсан хариу арга хэмжээг оновчтой, шуурхай зохион байгуулна. | - | -Шуурхай хариу арга хэмжээний тоо<br>- Дуудлагын төрөл, тоо | 2021 онд улсын хэмжээнд ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй нийт 240 дуудлагыг хүлээн авсан. | Зоонозын өвчний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний чадавхийг сайжруулснаар хүн амын өвчлөлийг бууруулсан байна. | Улсын хэмжээнд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар ЗӨСҮТ-д зоонозын халдварын хүний өвчлөлийн сэжигтэй байж болзошгүй нийт 673 дуудлагыг хүлээн авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Эдгээрийн 578(86%) хачигт халдвар, 61(9.0%) галзуугийн эрсдэлд өртсөн, 15(2.2%) бэтэг, 6(0.9%) тарваган тахал, 5(0.7%) листериоз, 4(0.6%) боом, 2(0.3%) хумхаа, 2(0.3%) ям өвчний сэжигтэй тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн дуудлага бүрт эрсдэлийн үнэлгээний дагуу халдварын дэгдэлтээс эрт сэрэмжлүүлэх шуурхай хариу арга хэмжээ авч халдвар эсэргүүцэх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | голомтыг цомтгон дарах ажлыг тухай бүр зохион байгууллаа. | |
| **Зорилт 2. Лабораторийн лавлагаа тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх** | | | | | | | |
| 2.1 | Лабораторийн үйл ажиллагаанд ISO15189 стандартыг нэвтрүүлж, итгэмжлэгдэнэ. | - | Гэрчилгээ | Урьдчилсан үнэлгээнд хамрагдах хүсэлт гаргах 16 зүйл заалтын өргөдөлийн материалыг бэлтгэн бэлэн болгосон. | Магадлан итгэмжлэгдсэн байна. | MNS ISO 15189:2015 итгэмжлэлийн материалыг шаардлагын дагуу бэлтгэн Лабораторийн итгэмжлэлийн газрын мэргэжилтэнд шалгуулан хүлээлгэж өгсөн.<br>2022 онд лабораторийн шинжилгээний 32 стандарт, 177 ажлын зааварт үнэлгээ хийж шинэчилсэн болон шинээр боловсруулан баталгаажуулсан.<br>MNS ISO 15189:2015 стандартын шаардлагыг хангах, үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой лабораторийн зөвлөх эмч ажиллуулан хамтран зөвлөгөө авч ажиллаж байна. MNS ISO 15189:2015 стандартын шаардлагыг хүрээнд лабораторит мөрдөгдөх журамд үнэлгээ хийсэн. | 60% |
| 2.2 | Зоонозын өвчний үүсгэгчийн генийн дараалал тогтоох фрагмент анализын судалгаа хийнэ. | - | Судалгааны ажлын тайлан | Фрагмент анализын арга зүйн анхан шатны сургалтад хамрагдсан. | Судалгааны ажлын тайлан гарсан байна. | *<u>“iSEQ-100 генийн дараалал тогтоох систем:</u>*<br>Япон улсын ЗГ-аас, Монгол улсын ЗГ-т “Ковид-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд “iSEQ-100, Illumina Next Generation Sequencer” машиныг дагалдах хэрэгсэл, оношлуур урвалжийн хамт хүлээн авч, онлайнаар суурилуулан 3 мэргэжилтэн анхан шатны сургалтад хамрагдсан ба SARS CoV -2 зэрэг дүнтэй 32 сорьцонд бүтэн геномын шинжилгээ хийсэн.<br>*<u>Генийн дараалал тогтоох судалгаа</u>*<br>Хачигт боррелиоз зэрэг дүнтэй *I. persulcatus* зүйлийн 26 хачигт 3130 генетик анализатороор генийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дараалал тодорхойлоход 1 сорьцод *B. afzelii*, 4 сорьцонд *B. garinii* зүйл байгааг тогтоож цаашид зоонозын халдварт өвчний молекул эпидемиологийн судалгааг хийх технологийг нэвтрүүллээ. | |
| 2.3 | Зоонозын халдварт зарим өвнүүдийн дархлаа тогтоцын судалгаа хийнэ. | | Судалгааны тайлан | - | Судалгааны ажлын тайлан гарсан байна. | Коронавируст халдварын дархлаа тогтоцыг тус төвийн ажилчдын дунд тодорхойлох зорилгоор 3 төрлийн оношлуур (Anti-SARS-CoV-2 ELISA IgA, Anti-SARS-CoV-2 QuantiVac ELISA IgG, Anti-SARS-CoV-2 NCP ELISA IgM) захиалан авч нийт 110 ажилтнаас 4 удаа сорьц цуглуулж давхардсан тоогоор 167 ийлдэст Коронавируст халдварын өвөрмөц эсрэгбие IgA, IgM, IgG-ийн таньцыг тогтоох шинжилгээг хийсэн.<br>Шинжилгээгээр эмч ажилчдын дархлаа тогтоцын түвшин тодорхойлогдсон. | 100% |
| 2.4 | Вирус судалын лабораторийг биоаюулгүй ажиллагааны III түвшний шаардлагад нийцүүлэн үе шаттай засварлана. | - | Үйл ажиллагаа нь тогтмолжсон Биоаюулгүй ажиллагааны III түвшний лаборатори | Ажиллаж эхлээгүй байна. | Биоаюулгүй ажиллагааны III түвшний лабораторийн үйл ажиллагаа тогтмолжсон байна. | Дэлхийн банкинд ЗӨСҮТ-ийн “Вирус судалын лабораторийг биоаюулгүй ажиллагааны III түвшний шаардлага”-д нийцүүлэн засварлах 500.000.000₮-ийн өртөг бүхий тооцооллыг хийж хүргүүлэн дэмжигдсэн бөгөөд ажлын зургийг шаардлагын дагуу боловсруулж засварын ажлыг 2023 онд эхлүүлэхээр 2 тал төлөвлөөд байна. | 100% |
| 2.5 | Шимэгч судлалын лабораторийг лавлагаа түвшинд үе шаттай хүргэж, хөгжүүлнэ. | - | Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | Төлөвлөгөөт ажлыг 100 хувь хэрэгжүүлнэ. | Шимэгч судлалын лабораторийг лавлагаа түвшинд үе шаттай хөгжүүлэх 8 заалт бүхий төлөвлөгөөг батлуулсан. Хэрэгжилт 100%. Үүнд: Лабораторийн 400 байнгын бэлдмэлийн хаягийг сольж шинэчилсэн<br>Шинээр хачгийн 5 наац бэлтгэн, шумуулын спиртэн цуглуулга 10 түбийг бэлтгэсэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Лабораторийн анхан шатны бүртгэлийг заарвын дагуу шинэчилсэн. Шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг үе шаттайгаар хийж байна.Үүнд: Шинээр 1 хөргөгч, 1 микроскоп, Жорж Масоны их сургууль (GMU), ЗӨСҮТ-тэй хамтран Монгол орны хачиг ба хачгаар дамжих халдварын үүсгэгчийн тархалтын судалгааны төслийн санхүүжилтээр лабораторийн ширээ, сандал, шүүгээ, хөшиг зэрэг тохижилтыг хийсэн. 8200 гадны шимэгчийг хүлээн авч зүйл тодорхойлон лабораторийн шинжилгээ хийж дүнг эргэн мэдээлсэн. | |
| **Зорилт 3. Зоонозын өвчний байгаль дахь тархалт, идэвхжлийг хянах, хүн амын дундах тархалт, эрсдлийн түвшин тогтоох тандалт судалгааг өргөжүүлэх** | | | | | | | |
| 3.1 | Хачгаар дамжих халдваруудын шинэ тохиолдлыг илрүүлэх журам боловсруулан хэрэгжүүлнэ. | - | Батлагдсан журам | Хачгаар дамжих халдваруудын шинэ тохиолдлыг илрүүлэх журмын төслийг боловсруулсан. | Шинээр батлагдсан журмыг мөрдөж ажилласан байна. | “Хачгаар дамжих халдваруудын шинэ тохиолдлыг илрүүлэх хариу арга хэмжээний түр заавар” төвийн Ерөнхий захирлын 2022 оны 11 сарын 01-ний өдрийн А/55 дугаар тушаалаар батлуулан орон нутагт хүргүүлж хэрэгжүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100% |
| 3.2 | Зоонозын өвчний эмнэлзүй, оношилгоо, эмчилгээ, тандалтын стандарт боловсруулж батлуулна. | - | Батлагдсан стандарт | Стандартыг боловсруулж ЭМЯ-ны Мэргэжлийн салбар зөвлөлд хүргүүлсэн. | Шинэ стандартыг мөрдөж эхэлсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Боловсруулан батлуулах стандарт, эмнэлзүйн заарвын жагсаалт батлах” тухай А/464 дүгээр тушаалын хавсралтад оношилгоо эмчилгээний заавраар батлуулан мөрдөн ажиллах шийдвэрийг хүлээн авч зоонозын халдварт өвчнүүдийг хяналт сэргийлэлтийн зааврuudыг шинэчлэн боловсруулж, эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | **“Алсын хараа- 2050” 2.2.39; МУХТЖҮЧ 2.2.6;** Зоонозын өвчний бүртгэл мэдээллийн программыг ЗӨСТ-үүдэд нэвтрүүлнэ. | - | Батлагдсан журам | Зоонозын өвчний мэдээллийн систем (ZIS) үндсэний төвд бүрэн нэвтэрсэн. | 15 ЗӨСТ-үүдийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байна. | Төвийн ерөнхий захирлын 2021 оны “Журам батлах тухай” А/42 дугаар тушаалаар тус программын үйл ажиллагаа зохицуулагдан ажиллаж байна.<br>2022 онд Зоонозын мэдээллийн систем ZIS программд нэмэлт хөгжүүлэлт хийж, аймаг, нийслэлийн ЗӨСТ-үүдийн хэрэглэгчийн эрхийг нэмж оруулсан ба ЗӨСТ-ийн эмч, мэргэжилтэн бүр нэвтрэх эрхтэй болсон. Орон нутгийн ЗӨСТ-үүдийн эмч, мэргэжилтнүүд тус системд дуудлага бүртгэх, бүртгэгдсэн дуудлагуудыг ангилж харах боломжтой болсон.<br>Орон нутагт программыг нэвтрүүлэхийн тулд хүний өвчлөл, амьтны дуудлага, лабораторийн бүртгэлийг хэрхэн бүртгэх талаар хэрэглэгчийн гарын авлагыг боловсруулж, түгээх ажлыг зохион байгуулсан. ЗӨСТ-үүдийн эмч, мэргэжилтнүүдийг программын гарын авлагаар хангаж, цахим сургалтыг 2022 оны 12-р сард зохион байгуулснаар орон нутгийн ЗӨСТ-д программыг үе шаттайгаарбүрэн нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.. Мөн орон нутгийн ЗӨСТ-ийн эмч, мэргэжилтнүүд 2013 оны нэгдүгээр сараас харьяалах нутаг дэвсгэрт бүртгэгдсэн зоонозын халдварын хүний өвчлөлийн мэдээллийг бүртгэж эхлэнэ. | 70% |
| 3.4 | Нийслэлийн нэг дүүрэгт сонгогдсон сургуулийн хүүхдийн дунд бэтэг өвчний тандалт судалгаа хийнэ. | - | Тандалт судалгааны тайлан | Нийслэлийн 2 дүүрэгт эзэнтэй нохойн дундах бэтэг өвчний халдваржилт | Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна. | Улаанбаатар хотын сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд хийх “Уйланхайт бэтэг өвчний тандалт судалгаа”-ны удирдамж | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | тогтоох судалгаа хийсэн. | | боловсруулан батлуулж, МХАОН, ХӨСҮТ, СХДЭМТ, Нийслэлийн ЗӨСТ-үүдтэй хамтран зохион байгуулсан. Улаанбаатар хотын СХД-ийн ЕБ-ын 107, 122, 152, 748, 121 дүгээр сургуулийн 1-11 дүгээр ангийн сурагчдыг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч, 2022 оны 11-р сарын 29-өөс 12-р сарын 02-нд ЗӨСҮТ-өөс боловсруулсан асуумжийг сонгогдсон 2136 хүүхдээс авч, хэвлийн хэт авиа оношилгоонд хамруулав. Судалгааны ажил үргэлжилж байна. | |
| 3.5 | Токсоплазмоз өвчний тархалт, эрсдэлт хүчин зүйлийн тандалт судалгаа хийнэ. | - | Тандалт судалгааны тайлан | - | Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна. | Монгол улсад Токсоплазмозын халдварын тархалтыг судлах зорилгоор идэвхитэй болон идэвхгүй тандалыг зохион байгууллаа. Үүнд: БЗД-ийн дэргэдэх оношилгооны лаборатори “Протолаб”, Интермэд, ЭХЭМҮТ, үр шилжүүлэн судлах төв болох Өжинмэд эмнэлэгээс 2020-2021 онд хийсэн Токсоплазмоз өвчний шинжилгээний нэгтгэсэн дүнгээр 0.98% (1116 хүний 11 хүн) нь Ig M эерэг, 0.79% (2026 хүний 16 хүн) нь IgG эерэг гарсан байв. Эх барихын ужиг дурьдатгалтай БЗД-ийн 44, Дархан-Уулын аймгийн 46 эмэгтэйчүүдүүс асуумж судалгаа, цусны ийлдэс цуглуулж, Токсоплазмоз шинжилгээнд хамруулахад 1 тохиолдол IgG эерэг дүн гарав. Токсоплазмозын гарын авлага боловсруулж хэвлүүлж, БЗД-ийн жирэмсэн эмэгтэйчүүдэд тараан сурталчилэв. Мөн танилцуулга бэлтгэж, байгууллагын вэб хуудаст байршуулав. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.6 | **“Алсын хараа- 2050” 2.2.1; МУЗГҮАХ 2.1.6** Булган, Сэлэнгэ аймагт хачигт энцефалит, хачигт боррелиоз, хачигт риккетсиозоор батлагдсан хүмүүсийн дунд эмнэл зүйн үлдэцийн судалгаа хийнэ. | 5.0 сая.төг (Төсөл хөтөлбөр) | Судалгааны ажлын тайлан | - | Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна. | Судалгаанд Сэлэнгэ аймгийн Хүдэр, Цагааннуур, Алтанбулаг, Ерөө, Зүүнбүрэн, Түшиг суманд хачигт хазуулж, эмнэл зүйн шинж тэмдэг илэрч эдгэрээд 1-18 жил (2002-2020) болсон 37 хүнийг хамрууллаа. Судалгаанд хамрагдсан хүмүүсээс 20 цусны ийлдэс цуглуулж, эсрэгбиеийн таньцыг үзэхэд 7 хүнд буюу хачигт энцефалитын халдвар авснаас хойш 1-12 (дундаж 4.8 жил) жилийн дараа эсрэгбие (иммуноглобулин IgG)-ийн таньц 1.5-3.6-тай байв. Энэ нь Халдвар авах үеийн таньцыг эдгэрсэнээс хойш буюу 1-2 жилийн дараа эсрэгбиеийн таньц 1.3-1.7 дахин буурсан байна.<br>Сэлэнгэ аймагт хачигт энцефалитаар өвчилж эдгэрсэн хүмүүсийн ихэнхи хувьд толгой өвдөх шинж, 40% орчимд мэдрэлийн гаралтай үлдэц шинж тэмдэгүүд илэрснээс мэнэн-энцефалит, саажсан хэлбэрээр өвчилсөн хүмүүст илүү хүнд хэлбэрийн мэдрэлийн үлдэц шинжүүд илэрч байна. | 100% |
| 3.7 | Булган, Сэлэнгэ аймгуудын нутагт мэрэгч амьтан, цус сорогч шавжийн (бүүрэг, шумуул, хөх түрүү, дэлэнч) зүйлийн бүрдэл тогтоох, япон энцефалит, баруун Нилийн халдвар, денги, хулгана тахал өвчний тандалт судалгаа хийнэ. | 6.0 сая.төг (Улсын төсөв) | Тандалт судалгааны тайлан | - | Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна. | Дархан-Уул аймгийн Төмөрлөгийн үйлдвэр ТӨХК, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Зүүнбүрэн, Цагааннуур сумдууд, Булган аймгийн Хялганат тосгон, Хангал сум, Орхон аймаг, Булган аймгийн Орхон сумын нутгийг хамрууллаа. 14 урт сүүлт зурам, 1 монгол тарвага олзворлож, өмхий хүрэн 1 үхдэл, амьтны үс ноолуураас 45 бүүрэг, 1 хачиг, гол, нуурын ай саваас 522 шумуул, 55 хөх түрүү цуглуулан тарваган тарваган тахал, баруун Нилийн халуурал, хулгана тахал, Япон | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | энцефалит, Денги халдвар илрүүлэх лабораторийн шинжилгээгээр сөрөг дүнтэй тодорхойлогдлоо. | |
| 3.8 | Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Улаанхус, Бугат сумдын нутагт тарваган тахал өвчний тандалт судалгааг хийж голомтот нутгийн төлөв байдлыг тогтооно. | 8.0 сая.төг (Улсын төсөв ОХУ-ын хөтөлбөрийн санхүүжилт) | Тандалт судалгааны тайлан | Тарваган тахал өвчний ын байгалийн голомт хяналтын тандалт судалгааг 321.000 га талбайд хийж гүйцэтгэн тайлан бичигдсэн. | Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна. | Баян-Өлгий аймгийн Улаанхус, Бугат, Ногооннуур (Цагааннуур тосгон), сумдын хил орчмын нутгийн 31 секторт хамрагдах 19 цэгт газрын 2463 кв.км талбайд тандалт шинжилгээг хийж гүйцэтгэв. Тарвага болон жижиг мэрэгчийн нийт 31 удаагийн маршрутын тооллогоор 172.3 мян. га талбайд хээрийн шинжилгээ судалгаа хийж ажиллаа. Судалгаагаар нийт 388 нэгж материал олзворлосноос мэрэгч амьтад (алтайн тарвага 21, урт сүүлт зурам 23, монгол огдой 39, дагуурын огдой 3, өмхий хүрэн 2) 88, мэрэгч амьтдын зэм үхдэл 147, гадны шимэгч 153 тус бүр лабораторийн шинжилгээнд хамруулан тарваганы зэмээс 19 тарваган тахлын нянгийн өсгөврийг илрүүлж 29 секторын 2240 кв.км талбайд эпизооти идэвхтэй явагдаж байгааг тогтоолоо. | 100% |
| 3.9 | Увс аймгийн Сагил, Бөхмөрөн сумдын нутагт тарваган тахал өвчний тандалт судалгааг хийж голомтот нутгийн төлөв байдлыг тогтооно. | 9.3 сая.төг (Улсын төсөв ОХУ-ын хөтөлбөрийн санхүүжилт) | Тандалт судалгааны тайлан | Тарваган тахал өвчний байгалийн голомтын тандал, хайгуул шинжилгээг 151200 га талбайд хийж гүйцэтгэн тайлан бичигдсэн. | Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна. | Увс аймгийн Бөхмөрөн, Сагил сумдын нийт 20 секторын 151200 га талбай хамруулснаас 8 секторт тандалт, 10 секторт хайгуул, ажиглалт хэлбэрээр тандалтыг гүйцэтгэж, нийт 1725 нэгж материал хамруулж Нийт шинжилсэн сорьц материалыг 100% хурдавчилсан сорил /ИХА тест/, нян судлал, молекул биологийн аргаар тус тус шинжлэв. 1725 нэгж материалыг ЗӨСҮТ-ийн лавлагаа лабораторид шинжилгээнд хамруулж тарваган тахлын нянгийн 2 өсгөвөр (*Y.pestis*) | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илрүүлж голомт идэвхитэй байгааг тогтоолоо. | |
| 3.10 | Дорнод аймгийн Халхгол, Чулуунхороот сумдын нутагт тарваган тахал, хам тохиолдох халдварт өвчний тандалт, шувууны томуу өвчний тандалт судалгаа хийнэ. | 5.3 сая.төг (Улсын төсөв) | Тандалт судалгааны тайлан | - | Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна. | 2 аймгийн 5 сумын 6 нууранд тандалт судалгаа хийж 55 зүйлийн 1016 шувуу тоолж бүртгэсэн. Тандалтын явцад сэжигтэй болон үхсэн шувууд таараагүй. 2 аймгийн ЗӨСТ-ийн 3 биологич, 2 лаборантад шувууг зөв таньж тодорхойлох мөн 2021 онд шинэчлэн батлагдсан шувууны тандалт судалгааны зааврыг хэрэгжүүлэх сургалт хийлээ.. Тандалтын явцад 20 сорьц цуглуулан бүх сорьцод түргэвчилсэн тестээр лабораторийн шинжилгээ хийхэд томуугийн эсрэг бие тодорхойлогдоогүй. Мөн төв суурин газарт ойр байрлах уст цэгийн тандалтыг 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Сонгинохайрхан дүүрэгт байрлах цэвэрлэх байгууламжийн ойролцоох 7-8 усан сангуудад хийж гүйцэтгэлээ. | 100% |
| 3.11 | Төв аймгийн 6 сумын нутагт хачгаар дамжих халдварт өвчний хүн амын дундах болон байгалийн голомтын тандалт судалгаа хийнэ. | 5.0 сая.төг (Улсын төсөв) | Тандалт судалгааны тайлан | - | Тандалт судалгааг хийж, тайлан гарсан байна. | Төв аймгийн 6 сумын нутагт хачгаар дамжих халдварт өвчний тандалт судалгааг хийж 82 иргэнээс асуумж, 51 хүний цуснаас сорьц авч ЗӨСҮТ төвийн лабораторид шинжлэхэд 13 иргэнд халдвар илэрснээс анаплазмозын халдвар хамгийн их буюу тандалт судалгаагаар илрүүлсэн нийт халдварын 61%-ийг эзэлж байна. Хачигт боррелиоз болон анзаарагддаггүй халдвар эрлихиозын халдваржилт илрээгүй. Тандалт судалгаанд хамрагдсан иргэдийн хувьд хачигт халдварын талаарх мэдлэг хангалтгүй, хачигт хазуулсан тохиолдолд зөв авах аргад суралцаагүй, хачигт халдваруудын талаарх мэдээлэл | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтмол авдаггүй байна. Тайгын хачгийн тархалтыг Батсүмбэр сумаас 1 цэгт, Жаргалант сумаас 2 цэгт газар шинээр тэмдэглэн бүртгэлээ.. *D.nutalli* зүйлийн 209, *I.persulcatus* зүйлийн 14 нийт 223 хачгийн ***54*** булинганд хачигт халдварын үүсгэгчийн нуклейн хүчил илрүүлэх молекул биологийн шинжилгээ хийж гүйцэтгэхэд нийт хачгийн 93.7% нь хачигт риккетсиозын, 1.34% нь анаплазмоз өвчний халдвартай болохыг тогтоосон. Мөн *D.nutalli* хачиг 100% хачигт риккетсиоз эерэг гарсан бол *I.persulcatus* хачгийн 21% нь анаплазмоз эерэг тодорхойлогдлоо. Төв аймгийн Мөнгөнморьт, Борнуур, Жаргалант, Эрдэнэ сумдын нутгаас цуглуулсан хачигт риккетсиоз болон анаплазмоз өвчний үүсгэгчийн өвөрмөц ДНХ илэрч шинжилгээ хийсэн цэгт газруудад дээрх өвчний халдвар хачгийн дунд орчиж байгааг тогтоолоо. | |
| 3.12 | Баян-Өлгий аймгийн тарваган тахлын байгалийн голомтын өндөр идэвхтэй бүс нутагт мэрэгчгүйтгэл шимэгчгүйтгэл хийнэ. | - | Мэрэгчгүйтгэл шимэгчгүйтгэл хийсэн талбайн хэмжээ | - | Төлөвлөсөн бүс нутагт мэрэгчгүйтгэл шимэгчгүйтгэлийг хийж, үр дүнг хянасан байна. | ЗӨСҮТ, Баян-Өлгий аймгийн ЗӨСТ-ийн хамтарсан баг удирдамжийн дагуу “Мэрэгчгүйтгэл шимэгчгүйтгэл хийх ажлын заавар” –ыг Төвийн ерөнхий захирлын 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/34 тоот тушаалаар Монгол улс ОХУ-ын хил орчмын бүс нутаг Баян-Өлгий аймгийн Сийлхэмийн нурууны хил орчмын тарваган тахлын байгалийн голомтын халдварын эрсдэлийг бууруулахаар Ногооннуур сумын Цагааннуур боомт орчим хүн амын суурьшлын бүсэд шимэгчгүйтгэл, мэрэгчгүйтгэлийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Нийт 4 секторийн 5 цэгт газрын 12000 га талбайн жижиг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэрэгчийн 5000, тарваганы 2000 нүхийг хамруулан шимэгчгүйтгэлийг хийж, тарвага 78, зурам 2 олзворлон устгалд оруулан мэрэгчгүйтгэлийг хийж үр дүнг тооцоход 97% тай байна. | |
| **Зорилт 4. Био үйлдвэрлэлийг хөгжүүлэх** | | | | | | | |
| 4.1 | Био-үйлдвэрлэлийн үйл ажиллагааны, технологи, стандарт ажиллагааны заавар, журмыг шинээр болон шинэчлэн боловсруулна. | - | Батлагдсан журам, технологи, стандарт ажиллагааны зааварын тоо | 2 журам, 2 технологийн заавар, 1 стандарт ажиллагааны заавар шинээр болон шинэчлэн боловсруулахаар төлөвлөж байна. | 2 журам, 2 технологийн заавар, 1 стандарт ажиллагааны заавар батлагдаж мөрдөж эхэлсэн байна. | Био-Үйлдвэрлэлийн лабораторт ажиллах журам, “Өвөрмөц тэжээлт орчин үйлдвэрлэлийн технологийн заавар” ,<br>Будаг, урвалж уусмал, будаг шингээсэн цаас үйлдвэрлэх технологийн заавар,<br>Тоосруулан хатааж хуурайшуулах төхөөрөмжийн стандарт ажиллагааны заавар зэрэг ажлын заврыг тус тус боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна. | 100% |
| 4.2 | **“Алсын хараа -2050” 2.2.28; МУЗГҮАХ 2.1.8.7**<br>Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах бэлтгэл хангана. | 3.0 сая. төг (Улсын төсөв ) | Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Тэжээлт орчин, будаг урвалж уусмал, биобэлдмэл үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн шалгуур үзүүлэлтийг хангах бэлтгэл ажил 75%-тай хийгдсэн. | Төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн байна. | Химийн хортой болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрөл авахаар нийт 292 химийн бодисын Химийн хор аюулын лавлах мэдээлэлийг гаргасан.<br>Химийн бодисын болзошгүй байдлын төлөвлөгөөг боловсруулсан.<br>ЗӨСҮТ-ийн МУ-ын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан “Биобэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх” хүрээнд хийсэн үйл ажиллаагааны тайланг бичиж ЗӨСҮТ-ийн тайлан, ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газарт албан тоотоор хүргүүлсэн.<br>Хар тамхи мансууруулах бодистой тэмцэх газраас “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис ” ашигладаг лаборатори, байгууллагыг урьдчилсан байдлаар | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үнэлэх үнэлгээний шалгалтад химийн лабораторийг танилцуулж үнэлгээний хуудсын дагуу 23 хуудас материал бүрдүүлж явуулсан.<br>Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагын статус нь өөрчлөгдөж Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар хариуцахаар өөрчлөгдсөн тул био үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгох Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газартай ЗӨСҮТ тохиролцож, тусгай зөвшөөрөл авах дэмжлэгт хяналтыг авч, зөвлөмжийн дагуу бэлтгэл ажлыг хангаж байгаа. | |
| **Зорилт 5. Хүн амыг зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг сайжруулах** | | | | | | | |
| 5.1 | Эрсдэлт бүлгийн хүн амд зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтыг оновчтой зохион байгуулна. | - | Дархлаажуулалтад хамрагдагсдын тоо | Тарваган тахал – 82.2%<br>Хачигт энцефалит- 87.6%.<br>Галзуу өвчний сэжигтэй мал, амьтанд уруулж ноцуулсан – 7731 хүн тус тус хамрагдсан. | Дархлаажуулалтын хамралтыг өмнөх оноос бууруулахгүй байна. | Улсын хэмжээнд 2022 онд тарваган тахлын эсрэг вакциныг 13 аймгийн 111 сум, нийслэлийн 7 дүүрэгт 24600 хүн тунг хүргүүлж, 86,4%-тай хамрагдсан байна.<br>Хачигт энцефалитын вакцин хамралт өмнөх жилүүдээс буурсан үзүүлэлттэй байна. Нийт I тунд 3247, II тунд 3208, II тунд 1867, сэргээх тунд 413 хүн хамрагдсан.<br>Галзуу өвчний сэжигтэй мал, амьтанд уруулж ноцуулж эрсдэлт өртсөн 7200 хүнд галзуугийн вакцин хийгдсэнээс 15.1% нь вакцин дутуу орхисон байна. Захиалгын дагуу мал амьтанд уруулж, ноцуулж, шүлсдүүлсний улмаас 57 хүнд 230 мл галзуугийн ийлдэс эмчилгээ хийгдсэн байна.<br>2022 онд боомын вакцин хийгдээгүй. | 100% |
| 5.2 | **МУХТЖҮЧ 2.2.2; МУЗГҮАХ 1.1.3.1**<br>Зорилтот бүлгийн иргэдэд зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх, | - | Хандалтын тоо | 2021 онд зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх | Мэдээлэл сургалт сурталчилгааны тоо өмнөх оноос буураагүй байна. | 2022 онд шинээр тарваган тахал 6, шумуул 2, хумхаа 4, шувууны томуу 1, бэтэг 5, галзуу 7, сармагчны цэцэг 5, токсоплазмоз 2, боом 5 **нийт 37** | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
